



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд 1,125,800,000.00 (нэг тэрбум нэг зуун хорин таван сая найман зуун мянган) төгрөгт багтаан 19 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2000 cc	13	48,400,000.00	629,200,000.00
2	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2000 cc	2	79,400,000.00	158,800,000.00
3	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 4608 cc	1	248,500,000.00	248,500,000.00
4	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2690 cc	1	34,400,000.00	34,400,000.00
5	Суудлын тоо 7, хөдөлгүүрийн багтаамж 2690 cc	2	27,450,000.00	54,900,000.00
	Нийт дүн			1,125,800,000.00 (нэг тэрбум нэг зуун хорин таван сая найман зуун мянган)